



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Шивээ-Овоо” хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 959.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Шивээ-Овоо” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхтувшинд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх, шинээр олж аваходаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

2.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдаж, авлага, өглөгийг бууруулж ажиллах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар нэхэмжлэх;

2.4. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөр аудитын байгууллагыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох асуудлыг хэлэлцүүлж байх;

2.5. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийсэн Шивээ-Овоогийн нүүрсний ордын талбай дээр хайгуулийн тусгай зөвшөөрөл олгосон асуудлыг таслан зогсоохыг Ашигт малтмал, газрын тосны газарт мэдэгдэж, хууль хяналтын байгууллагаар шалгуулах;

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХӨЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000720